



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг<sup>1</sup>)

### ЭРХ МЭДЭЛ АЛБАН ТУШААЛЫН БАЙДЛАА УРВУУЛАН АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТИВ ШИНЖ: АЧ ХОЛБОГДОЛ

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** Дугаар 148

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

**Шүүхийн шийдвэрийн төлөв:** Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан.

#### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ:

Цагаатгагдсан шүүгдэгч нь сумын Засаг даргаар ажиллаж байх хугацаандаа албан үүрэг, бүрэн эрхээ урвуулан ашиглаж, сахилгын шийтгэлтэй албан хаагчид 300.000 төгрөгийн урамшуулал олгох тухай захирамж гарган эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт холбогджээ.

#### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР:

- Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн (2015) тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах”<sup>2</sup> гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, мөн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан<sup>3</sup> нийтийн албанд томилогдох эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 5,400,000 төгрөгөөр торгох ял шийтгэжээ.

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

[https://shuukh.mn/single\\_case/3500?daterange=2023/01/01%20-%202023/11/26%20&id=3&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/3500?daterange=2023/01/01%20-%202023/11/26%20&id=3&court_cat=2&bb=1)

<sup>2</sup> Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” /Энэ зүйлийг 2017.05.11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

<sup>3</sup> Эрүүгийн хуулийн тусгай ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно.”

2. Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн **давж заалдах шатны шүүх** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.
3. **Шүүгдэгчийн өмгөөлөгч хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо** “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад миний үйлчлүүлэгчийн сэдэлт зорилгыг тогтоогоогүй бөгөөд гэм буруутай эсэх нь субъектив шинжээрээ үгүйсгэгдэж байна. Иймд хоёр шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж өгнө үү” гэх агуулга бүхий гомдлыг гаргажээ.
4. **Хяналтын шатны шүүхээс** эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив шинжийг судлан үзвэл тусгай субъект буюу нийтийн албан тушаалтан албаны чиг үүргийн хувьд гэм буруугийн **зөвхөн шууд санаатай хэлбэрээр** хуулиар зөвшөөрөгдөөгүй буюу хориглосон үйлдлийг гүйцэтгэх, эсхүл хуульд заасны дагуу хийх ёстой зүйлийг хийж гүйцэтгээгүйн улмаас өөртөө болон бусдад хууль бус давуу байдал олгосон байх шинжийн нэгдлийг гэмт хэрэгт тооцохоор зохицуулжээ. (31)<sup>4</sup>
5. Гэрчүүдийн мэдүүлэг болон бусад нотлох баримтаар шүүгдэгч нь төрийн албан хаагчдад урамшуулал олгох тухай захирамжид гарын үсэг зурж, сахилгын шийтгэлтэй албан хаагчид 300,000 төгрөгийн урамшуулал олгохыг хүсэж, ингэхдээ албан тушаалын байдлаа хэрхэн урвуулан ашигласан нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар эргэлзээгүй, хөдөлбөргүй тогтоогдоогүй байна. (32)
6. Харин шүүгдэгч нь сумын Засаг даргын тамгын газрын дарга болон бусад албан хаагчдын бүрдүүлсэн баримт бичгийг хянах, нягтлан шалгах үүргийг зохих ёсоор биелүүлэлгүй, урамшуулал олгох тухай захирамжид гарын үсэг зурсан нь “Албан үүрэгтээ хайнга хандах”<sup>5</sup> гэмт хэргийн үндсэн шинжийн объектив талыг хангаж байх боловч уг гэмт хэрэг нь бусдад их хэмжээний хохирол учирсан байхыг шаарддаг тул шүүгдэгч албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйг эрүүгийн гэмт хэрэг бус зөрчлийн шинжтэй гэж үзнэ. (33)
7. Иймд тус хэргийг “гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгаж; холбогдох баримт бичгийг нягтлан шалгалгүйгээр гарын үсэг зурсан явдлыг эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэж, хариуцлага тооцоход уг тогтоол саад болохгүйг тэмдэглэж” шийдвэрлэжээ.

---o0o---

---

<sup>4</sup> “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

<sup>5</sup> Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Албан тушаалтан хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол...”